

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/31/СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Аудитор: Д.Мөнхжин Утас: 260512 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.....	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
Аудитын зөвлөмж.....	13
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ
ТАНАА

2021.04.26 № 1310

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар худалдан авах ажиллагааны хууль журам зөрчсөн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, дотоод хяналт хангалтгүйгээс нийт 224.2 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давж, холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	380,449.2	317,432.0
33	АВЛАГА	7,670.0	0.0
34	УРЬДЧИЛГАА	36,965.6	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	335,813.6	317,432.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,597,180.6	6,288,314.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,597,180.6	6,288,314.7
39200	Биет хөрөнгө	6,311,474.2	5,933,221.9
39300	Биет бус хөрөнгө	285,706.4	355,092.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,977,629.8	6,605,746.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	119.3	123.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	119.3	123.2
41300	Өглөг	119.3	123.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,977,510.5	6,605,623.5
51	Засгийн газрын хувь оролцоо	6,977,510.5	6,605,623.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,428,220.1	1,428,220.1
51200	Хуримтлагдсан үр дүн	4,149,454.0	3,777,567.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,399,836.3	1,399,836.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,977,629.8	6,605,746.6

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,813,724.8	4,591,016.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,998.3	0.0
120	Нийтлэг татварын бус орлого	7,998.3	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,805,726.5	4,591,016.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,136,803.7	4,962,903.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,136,803.7	4,962,903.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,485,558.3	3,849,835.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,382,474.3	2,620,111.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	298,366.9	320,392.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,118.8	85,945.7
2104	Хангамж, бараа материалын зардал	77,348.4	99,860.2
2105	Нормативт зардал	0.0	392.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,808.3	17,007.0
2107	Томилолт, зочны зардал	129,803.5	19,095.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,147.7	94,694.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	397,490.4	592,337.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,651,245.4	1,113,067.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,676,921.1	-371,887.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,676,921.1	-371,887.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,808,236.4	4,590,771.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,509.8	0.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,509.8	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,805,726.5	4,590,771.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,907,100.6	4,451,818.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,907,100.6	4,451,818.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,256,541.0	3,338,795.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,332,237.5	2,537,446.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	349,762.9	403,088.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,118.8	85,945.7
2104	Хангамж, бараа материалын зардал	98,264.9	112,938.6
2105	Нормативт зардал	0.0	1,141.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,117.8	61,359.0
2107	Томилолт, зочны зардал	133,904.6	19,095.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,205.0	99,263.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,929.5	18,517.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,650,559.6	1,113,023.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,901,135.7	138,952.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,901,135.7	138,952.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,901,135.7	138,952.6
2200	Дотоод эх үүсвэрээр	3,901,135.7	138,952.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,901,135.7	-138,952.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

		/мянган төгрөгөөр/	
Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,300,589.4	-	3,300,589.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,300,589.4	-	3,300,589.4
Тайлант үеийн үр дүн	3,676,921.1	-	3,676,921.1
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,977,510.5	-	6,977,510.5
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,977,510.5	-	6,977,510.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,977,510.5	-	6,977,510.5
Тайлант үеийн үр дүн	-371,887.0	-	-371,887.0
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,605,623.5	-	6,605,623.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,728,878,000.00	3,505,059,067.78	1,223,818,932.22	74.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,728,878,000.00	3,505,059,067.78	1,223,818,932.22	74.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,571,331,000.00	3,477,747,687.78	1,093,583,312.22	76.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,989,870,500.00	2,537,446,136.20	452,424,363.80	84.87
210101	Үндсэн цалин	2,025,105,600.00	1,727,408,119.77	297,697,480.23	85.30
210102	Нэмэгдэл	770,830,100.00	637,522,484.09	133,307,615.91	82.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	159,625,400.00	147,515,532.34	12,109,867.66	92.41
210104	Урамшуулал	34,309,400.00	25,000,000.00	9,309,400.00	72.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	403,632,600.00	403,088,800.00	543,800.00	99.87
210201	Тэтгэврийн даатгал	284,037,800.00	403,088,800.00	-119,051,000.00	141.91
210202	Тэтгэмжийн даатгал	29,898,700.00	0.00	29,898,700.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,919,000.00	0.00	23,919,000.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,979,700.00	0.00	5,979,700.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	59,797,400.00	0.00	59,797,400.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,262,100.00	85,945,689.54	11,316,410.46	88.37
210301	Гэрэл, цахилгаан	27,456,600.00	27,557,082.68	-100,482.68	100.37
210302	Түлш, халаалт	27,011,100.00	30,855,004.53	-3,843,904.53	114.23
210303	Цэвэр, бохир ус	8,729,400.00	3,066,602.33	5,662,797.67	35.13
210304	Байрны түрээс	34,065,000.00	24,467,000.00	9,598,000.00	71.82
2104	Хангамж, бараа материалын зардал	193,423,700.00	112,938,641.31	80,485,058.69	58.39
210401	Бичиг хэрэг	43,563,800.00	34,541,219.00	9,022,581.00	79.29
210402	Тээвэр, шатахуун	44,706,400.00	27,850,000.00	16,856,400.00	62.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,056,000.00	24,325,424.31	27,730,575.69	46.73
210404	Ном, хэвлэл	25,090,300.00	7,222,200.00	17,868,100.00	28.78
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,122,000.00	3,679,450.00	1,442,550.00	71.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,885,200.00	15,320,348.00	7,564,852.00	66.94
2105	Нормативт зардал	4,656,900.00	1,141,300.00	3,515,600.00	24.51
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,656,900.00	1,141,300.00	3,515,600.00	24.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	306,307,500.00	165,911,631.00	140,395,869.00	54.17
210601	Багаж, техник, хэрэгсэл	138,302,400.00	131,969,241.00	6,333,159.00	95.42
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,062,000.00	4,974,000.00	1,088,000.00	82.05
210604	Урсгал засвар	161,943,100.00	28,968,390.00	132,974,710.00	17.89
2107	Томилолт, зочны зардал	162,476,600.00	19,094,980.00	143,381,620.00	11.75

210702	Дотоод албан томилолт	126,419,800.00	19,094,980.00	107,324,820.00	15.10
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	36,056,800.00	0.00	36,056,800.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	267,358,700.00	133,663,019.73	133,695,680.27	49.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,284,800.00	220,000.00	38,064,800.00	0.57
210803	Даатгалын үйлчилгээ	72,270,000.00	42,987,347.12	29,282,652.88	59.48
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,245,500.00	2,849,285.00	396,215.00	87.79
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	137,137,200.00	73,694,663.61	63,442,536.39	53.74
210807	Газрын төлбөр	16,421,200.00	13,911,724.00	2,509,476.00	84.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,342,400.00	18,517,490.00	127,824,910.00	12.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,977,200.00	1,480,000.00	3,497,200.00	29.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	141,365,200.00	17,037,490.00	124,327,710.00	12.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,547,000.00	27,311,380.00	130,235,620.00	17.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	157,547,000.00	27,311,380.00	130,235,620.00	17.34
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	136,247,000.00	17,215,380.00	119,031,620.00	12.64
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,300,000.00	10,096,000.00	11,204,000.00	47.40
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,728,878,000.00	3,505,059,067.78	1,223,818,932.22	74.12
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,728,878,000.00	3,505,059,067.78	1,223,818,932.22	74.12
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,728,878,000.00	3,505,059,067.78	1,223,818,932.22	74.12
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	129	104	25	80.62
620001	Удирдах ажилтан	10	10	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	89	70	19	78.65
620003	Үйлчлэх ажилтан	30	24	6	80.00
650003	Ажлын албан хаагч /АА/	71	55	16	77.46
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	33	24	9	72.73
650012	Шүүгч прокурор	25	25	0	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,825,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,825,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,825,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,825,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,825,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,825,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,825,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,825,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Д.Мөнхжин нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1192 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Дээд шүүх нь эрхэм зорилгоо “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ажлын албаны дотоод аудитор нь 2018 оноос 2020 оны 1 дүгээр улирлын цалингийн тооцоолол, нэмэгдэл урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгосон эсэх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,962.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 99.2 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 371.9 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	7.7	0.0	(7.7)
Урьдчилгаа	36.9	0.0	(36.9)
Бараа материал	335.8	317.4	(18.4)
Үндсэн хөрөнгө	6,597.2	6,288.3	(308.9)
Нийт хөрөнгө	6,977.6	6,605.7	(371.9)
Өр төлбөр	0.1	0.1	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,977.5	6,605.6	(371.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,977.6	6,605.7	(371.9)

Урьдчилгаа дансны үлдэгдэл 36.9 сая төгрөгөөр буурч, үлдэгдэлгүй болсон нь урьдчилгаа дансанд бүртгэлтэй байсан сургалт мэдээллийн төвийн зураг төслийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 317.4 сая төгрөг болж 18.4 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материалын үлдэгдэл буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,288.3 сая төгрөг болж 308.9 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны А-1/1773 дугаар тогтоолын дагуу 34.8 сая, А-1/792 дугаар тогтоолын дагуу 128.5 сая төгрөгийн хөрөнгүүдийг акталж, 756 дугаар тогтоолын дагуу 1.6 сая төгрөгийн хөрөнгийг дүүргүүдийн Эрүүгийн анхан шатны шүүх, 540 дугаар тогтоолоор 55.6 сая төгрөгийн хөрөнгийг сум дундын шүүх, А-1/376 дугаар тогтоолоор 51.5 сая төгрөгийн хөрөнгийг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, 352 дугаар тогтоолоор 25.0 сая төгрөгийн хөрөнгийг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд балансаас баланст тус тус шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 371.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого 53.3 хувь буюу 5,239.7 сая төгрөгөөр, нийт зардал 19.1 хувь буюу 1,190.9 сая төгрөгөөр өмнөх оноос тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 21,196.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2020 оны төсвийн хязгаарыг 5,078.3 сая төгрөгөөр баталсан ба төсвийн ерөнхийлөн захирагч 21,196.5 сая төгрөгийн төсвийн төсөл боловсруулж хүргүүлснийг 16,467.6 сая төгрөгөөр бууруулж 4,728.9 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарлагыг хэт өндрөөр, бодит бус, үндэслэлгүй боловсруулсан, төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцээгүй тул бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 4,728.9 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4,588.9 сая төгрөгийг олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,505.0 сая төгрөг буюу 74.1 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 452.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 140.4 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 143.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1,083.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлтээр 1.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна. Өмгөөллийн тухай хууль хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан өмгөөлөгчдийн хураамжийг Монгол Улсын Дээд шүүх хариуцаж бүрдүүлэхээ больсон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 120 дугаар зарлигаар нэр бүхий 5 шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар зарлиг, 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 145 дугаар зарлигаар 4 шүүгчийн бүрэн эрхийг сэргээсэн бөгөөд Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны төсвөөс эдгээр шүүгчдийн эрхийг түдгэлзүүлсэн хугацааны 214.0 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын Дээд шүүх 2020 онд хяналтын шатны эрүүгийн, иргэний, захиргааны нийт 2920 хэрэг хуулийн хугацаанд шийдвэрлэхээр төлөвлөснөөс 2498 хэргийг шүүн тасалсан байна. Энэ нь өмнөх оныхоос 4.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Шийдвэрлэсэн хэрэг буурсан шалтгаан нь шүүх бүрэлдэхүүн дутуу ажилласан мөн Ковид-19 цар тахлын үеийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор шүүх хуралдааны зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбоотой байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 55 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож 122 мэдээлэл, 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 80.1 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	4	80.1	4	80.1	100.0
Нийт дүн	4	80.1	4	80.1	100.0

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 224.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 156.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 67.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 156.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, нийт 154.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг 3 аж ахуйн нэгж, байгууллагатай шууд гэрээ байгуулж худалдан авах ажиллагааны хууль, журмыг хэрэгжүүлэхгүй худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4 дэх хэсэгт "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Цалингийн зардлаас 2.5 сая төгрөгийг урамшуулалд ангилал буруу зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 55 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож 122 мэдээлэл, 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 67.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Урьдчилж гарсан зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Даатгал болон түрээсийн төлбөрийн дараа онд ногдох 49.6 сая төгрөгийн дүнг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Даатгалын болон түрээсийн гэрээнүүдийг хамрах хугацааг тооцож, тайлант онд ногдох зардлыг тооцоолон зардлаар хүлээн зөвшөөрөх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хөрөнгийн дансанд бүртгэлтэй 749.7 сая төгрөгийн анхны өртөгтэй 9 ширхэг авто тээврийн хэрэгсэл, 272.9 сая төгрөгийн анхны өртөгтэй 204 ширхэг тоног төхөөрөмж, 129.4 сая төгрөгийн анхны өртөгтэй 608 ширхэг тавилга, эд хогшил зэрэг элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам" 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 7.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.30-д "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө. Хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай үнэлэх боломжтой" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж

Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Урсгал засварын зардлаас 2.8 сая төгрөгийн цэвэрлэгээний материал, багаж техник хэрэгслийн зардлаас 7.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, нийт 10.2 сая төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх.

4.3. Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хавсралт

Огноо:	Аудитын нэр:	Монгол Улсын Дээд шүүхийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.04.25			САГ-2021/31/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Дээд шүүх		Сая төгрөг:

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Даатгал болон түрээсийн төлбөрийн дараа онд ногдох 49.6 сая төгрөгийн дүнг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	49.6	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга Ахлах нягтлан бодогч	С.Амардэлгэр А.Эрдэнэцэцэг
2	Хөрөнгийн дансанд бүртгэлтэй 749.7 сая төгрөгийн анхны өртөгтэй 9 ширхэг авто тээврийн хэрэгсэл, 272.9 сая төгрөгийн анхны өртөгтэй 204 ширхэг тоног төхөөрөмж, 129.4 сая төгрөгийн анхны өртөгтэй 608 ширхэг тавилга, эд хогшил зэрэг элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга Ахлах нягтлан бодогч	С.Амардэлгэр А.Эрдэнэцэцэг
3	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 7.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	7.9	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга Ахлах нягтлан бодогч	С.Амардэлгэр А.Эрдэнэцэцэг
4	Урсгал засварын зардлаас 2.8 сая төгрөгийн цэвэрлэгээний материал, багаж техник хэрэгслийн зардлаас 7.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, нийт 10.2 сая төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулсан байна.	10.2	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга Ахлах нягтлан бодогч	С.Амардэлгэр А.Эрдэнэцэцэг
5	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, нийт 154.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг 3 аж ахуй нэгж, байгууллагатай шууд гэрээ байгуулж тендерийн хууль, журмыг хэрэгжүүлэхгүй худалдан авалт хийсэн байна.	154.0	Албан шаардлага	Тамгын газрын дарга Ахлах нягтлан бодогч	С.Амардэлгэр А.Эрдэнэцэцэг
6	Цалингийн зардлаас 2.5 сая төгрөгийг урамшуулалд ангилал буруу зарцуулсан байна.	2.5	Албан шаардлага	Тамгын газрын дарга Ахлах нягтлан бодогч	С.Амардэлгэр А.Эрдэнэцэцэг
7	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 120 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Албан шаардлага	Тамгын газрын дарга Ахлах нягтлан бодогч	С.Амардэлгэр А.Эрдэнэцэцэг
ДҮН		224.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 543/АО110001

Улаанбаатар хот

С.АТ-2021/31/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, нийт 154.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг 3 аж ахуйн нэгж, байгууллагатай шууд гэрээ байгуулж худалдан авах ажиллагааны хууль, журмыг хэрэгжүүлэхгүй худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж, хуульд заасан арга хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Амардэлгэр, Ахлах нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 544/АОМ0001

Улаанбаатар хот

С.АТ-0021/31/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалингийн зардлаас шагнал, урамшуулалд зориулж нийт 2,500,000.00 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Амардэлгэр, Ахлах нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

001681207



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 545/А0110001

Улаанбаатар хот

СЯТ-2021/31/СТА-ТӨЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс 122 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 4 мэдээллийг цахим системд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Амардэлгэр, Ахлах нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ